



АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн хөгжлийн бодлогын зорилго нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “АЛСЫН ХАРАА-2050”, Төрөөс шинжлэх ухаан, технологи, боловсрол, эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Тогтвортой хөгжлийн зорилт-2030, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, АШУҮИС-ийн тогтвортой хөгжлийг хангахад оршино.

Хөгжлийн бодлогыг Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7, Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.12, Эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт, АШУҮИС-ийн дүрэм болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан ба 2021-2030 онд АШУҮИС-ийн хөгжлийн бодлогыг тодорхойлох үндсэн баримт бичиг болно.

Хоёр. Алсын хараа

Дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болно.*

Гурав. Эрхэм зорилго

Шинжлэх ухаан, боловсрол, эрүүл мэндийн салбарт манлайлагч их сургууль байхад оршино.

Дөрөв. Уриа

Эрүүл ирээдүйг хамтдаа бүтээе.

Тав. Бидний үнэт зүйлс

Бидний бүтээсэн түүх, оюуны бүтээл, нэр хүнд, эв нэгдэл Эрдэм мэдлэг, ёс зүйтэй, чадварлаг багш, судлаач, эмч нар Эрдэмд шамдагч, эрүүл чийрэг, эрч хүчтэй оюутан залуус Бүтээлч, манлайлагч, манай төгсөгчид

* International Ranking Expert Group, Observatory on Academic Ranking & Excellence байгууллагаас гаргадаг дэлхийн их сургуулиудын чансааны UniRank эрэмбэ (2020 оны байдлаар 7934 дүгээрт эрэмбэлэгдсэн).



Зургаа. АШУҮИС-ийн үзэл баримтлал

- Үзэл санаа, зохион байгуулалт, үйл ажиллагаа нэгдмэл байх;
- Эрдэм мэдлэгт шамдан суралцаж, хүнлэг энэрэнгүй байх;
- Эрч хүчтэй, бүтээлч, санаачилга, хариуцлагатай ажиллах;
- Уламжлал-шинэчлэлийг хослуулан бодлого, үйл ажиллагааны залгамж чанарыг хангах;
- Нээлттэй, шударга, тэгш, чадахуйн зарчимд тулгуурлах;

Долоо. Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

1. АШУҮИС-ийн тогтвортой хөгжлийг хангах;
2. Үндэсний онцлог болон байгууллагын давуу талд тулгуурласан байх;
3. Эрдмийн эрх чөлөөг дээдлэх;
4. Шинжлэх ухааны нотолгоонд суурилсан байх;
5. Олон улсад их сургуулиудыг эрэмбэлэх шалгуурт үндэслэсэн байх;
6. Өвөрмөц, хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, бодитой, цаг хугацаатай, сорилт болохуйц байх;
7. Нөөцийн болон төсвийн бодит боломжид тулгуурласан байх;

Найм. Хөгжлийн бодлогын зорилт

1. Шилдэг багш, судлаач, эмчийн мэргэшсэн багийг бүрдүүлж, тасралтгүй хөгжлийг дэмжих;
2. Олон улсын жишигт нийцэхүйц судалгааны орчин, нөхцөлийг бүрдүүлсэн үндэсний тэргүүлэгч судалгааны их сургууль болох;
3. Дэлхийд өрсөлдөх чадвартай эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх;
4. Сургалтын ээлтэй орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн их сургуулийн хотхон байгуулах;
5. Их сургуулийн эмнэлгийн тогтолцоог хөгжүүлж, олон улсын жишигт хүргэх;
6. Их сургуулийн тогтвортой хөгжлийг хангах эрх зүйн шинэчлэл хийх;
7. Ил тод, цомхон, хариуцлагатай, үр нөлөөтэй сайн засаглалыг бэхжүүлэх;
8. Эрдэм шинжилгээ, сургалт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, удирдлагын мэдээлэл технологийн нэгдсэн тогтолцоонд шилжих;
9. Санхүү, хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэх;



Ес. Хэрэгжүүлэх стратеги, арга зам, хэмжих үзүүлэлт

Зорилт 1: Шилдэг багш, судлаач, эмчийн мэргэшсэн багийг бүрдүүлж, тасралтгүй хөгжлийг дэмжих			
№	Хэрэгжүүлэх стратеги	Арга зам	Хэмжих үзүүлэлт
1.1	Дотоод, гадаадын шилдэг багш, судлаач, эмчийг урьж ажиллуулна.	1. Олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн багш, судлаач, эмч нарыг урьж, тогтвортой ажиллуулна. 2. Гадаад багшийн тоог нэмэгдүүлнэ	<ul style="list-style-type: none"> ● Дэлхийн их сургуулийн эрэмбийн судалгаанд нэр дурдагдсан багш, судлаачийн тоо ● Урьж ажиллуулсан шилдэг багш, судлаач, эмчийн тоо ● Үндсэн багшийн эзлэх гадаад багшийн хувь
1.2.	Багш, судлаач, эмч нарын тасралтгүй хөгжлийг дэмжинэ.	1. Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ. 2. Багшийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. 3. Докторын дараах судлаачийн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлнэ. 4. Багш, судлаач, эмчийн насан туршийн нээлттэй боловсролыг дэмжинэ. 5. Багшийн ажлын үнэлгээ, ажилтнуудын чадамжид суурилсан урамшууллын механизмыг бүрдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ● Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь ● Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь ● Багшийн хөгжилд зориулсан санхүүжилтийн хэмжээ ● Тэтгэлэгт хамрагдсан докторын дараах судлаачийн тоо ● Багшийн ажлын үнэлгээний дундаж өсөлт ● Мэргэжлийн зэрэгтэй багш, эмчийн эзлэх хувь ● Ажилтны суурь ур чадварын үнэлгээний өсөлт
1.3.	Багш, эмч, ажилтнуудын хөдөлмөрлөх таатай орчин, нийгэм хамгааллыг сайжруулна.	1. Багш, ажилтны цалин, урамшууллыг тогтмол нэмэгдүүлнэ. 2. Эрүүл ажлын байр хөтөлбөр хэрэгжүүлнэ. 3. Багш, ажилтнуудын нийгэм хамгааллыг сайжруулна.	<ul style="list-style-type: none"> ● Багш, ажилтны цалингийн өсөлт ● Багш, ажилтны сэтгэл ханамжийн өсөлт ● Ажлын байрны эрүүл ахуйн орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийн хувь ● Эрүүл ажлын байр хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь ● Багш, эмч, ажилтнуудын орон сууц, нийгэм хамгааллыг дэмжих чиглэлээр шинээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо



Зорилт 2: Олон улсын жишигт нийцэхүйц судалгааны орчин, нөхцөлийг бүрдүүлсэн үндэсний тэргүүлэгч судалгааны их сургууль болох			
№	Хэрэгжүүлэх стратеги	Арга зам	Хэмжих үзүүлэлт
2.1	Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл үйлдвэрлэх орчин, нөхцөлийг бүрдүүлнэ..	<ol style="list-style-type: none"> 1. Үндэсний болон олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдсэн салбар дундын судалгааны төв, эрдэм шинжилгээний хүрээлэн, жишиг төв, лаборатори байгуулна. 2. Төгсөлтийн сургалтын суралцагчдад олгох судалгааны тэтгэлгийг нэмэгдүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> • Био-Анагаахын хүрээлэн, Био-аюулгүй байдлын 2 дугаар зэрэглэлийн лавлагаа лаборатори, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Салбар дундын судалгааны жишиг төв, Эмнэлзүйн молекул оношилгооны төв байгуулсан байх • Анагаах ухааны хүрээлэнгийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны тоо • Үндэсний болон олон улсын түвшинд магадлан итгэмжлэгдсэн лабораторийн тоо • Эрдэм шинжилгээний нэгжүүдийг түшиглэн хэрэгжүүлсэн төслийн тоо • Төгсөлтийн сургалтын суралцагчдад олгосон судалгааны тэтгэлгийн тоо
2.2.	Эрдэм шинжилгээний бүтээлийн чансааг нэмэгдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> 1. Эрдэм шинжилгээний бүтээлийн олон улсын санд бүрдгэгдсэн сэтгүүлд хэвлүүлэх бүтээлийн тоог нэмэгдүүлнэ. 2. АШУҮИС-аас эрхлэн гаргадаг сэтгүүлийг эрдэм шинжилгээний бүтээлийн олон улсын санд бүрдгүүлнэ. 3. Үндэсний хэмжээний анагаах ухааны сэтгүүл эрхлэн гаргана. 	<ul style="list-style-type: none"> • Web of Science, Scopus, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо • Олон улсын Web of Science, Scopus, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй АШУҮИС-аас эрхлэн гаргадаг сэтгүүлийн тоо • Дотоодын сэтгүүлийн чансааг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны тоо
2.3.	Хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхүйц, эрүүл мэндийн технологи,	<ol style="list-style-type: none"> 1. Эмнэлзүйн судалгааны үндэсний удирдамж, стандартыг батлуулна. 2. Их сургуулийн эмнэлэгт эмнэлзүйн судалгааны олон улсын стандартыг нэвтрүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> • Эмнэлзүйн судалгааны үндэсний удирдамж, стандартыг батлуулсан байна. • Их сургуулийн эмнэлэгт эмнэлзүйн судалгааны олон улсын стандартыг нэвтрүүлсэн байна.



	тусламж, үйлчилгээнд инноваци нэвтрүүлэх эмнэлзүйн туршилт судалгааг эрчимжүүлнэ.	3. Их сургуулийн брэнд, инновацийн бүтээгдэхүүнүүдийг бодлогоор дэмжин, технологи дамжуулан зүгшрүүлж, арилжаалах тогтолцоог бүрдүүлж, салбар дундын судалгааг дэмжин хөгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ● Монгол Улсын язгуур эрх ашиг, үндэсний аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг хөндсөн эмнэлзүйн судалгааг гүйцэтгэсэн тоо ● Монгол Улсад нэвтрүүлсэн эрүүл мэндийн шинэ технологийн тоо ● Инновацийн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэхэд чиглэсэн эмнэлзүйн судалгааны бүтээлийн тоо ● Инновацийн шинэ бүтээгдэхүүнээс их сургуульд оруулсан орлогын хэмжээ
2.4.	Оюуны өмчийн хамгаалалт, баталгаажуулалтыг сайжруулна.	<ol style="list-style-type: none"> 1. Оюуны өмчийн хамгаалалт, хадгалалтыг сайжруулна. Бүтээлийн нэгдсэн сан үүсгэнэ. 2. Оюуны өмчийн бүх хэлбэрийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог бүрдүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> ● Бүтээлийн хуулбарлалт шалгах программыг нэвтрүүлсэн байдал Бүтээлийн нэгдсэн сан үүсгэн эдийн засгийн эргэлтэд оруулж зохиогчдод ээлтэй тогтолцоог бүрдүүлсэн байдал ● Оюуны өмчийн тоо ● Шинээр нэвтрүүлсэн эрүүл мэндийн технологи, брэнд бүтээгдэхүүний тоо

Зорилт 3: Дэлхийд өрсөлдөх чадвартай эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх

№	Хэрэгжүүлэх стратеги	Арга зам	Хэмжих үзүүлэлт
3.1.	Сургалтын технологид инноваци, сайн туршлагыг нэвтрүүлнэ.	<ol style="list-style-type: none"> 1. Энэрэнгүй, бүтээлч, хөрвөх чадвартай эмч, судлаач, мэргэжилтэнг бэлтгэх чиглэлээр инноваци, сайн туршлагыг нэвтрүүлнэ. 1. Эмнэлзүйн суралцах орчны олон улсын стандарт, шалгууруудаас нэвтрүүлж Монгол Улсын жишиг их сургуулийн эмнэлэг болно. 	<ul style="list-style-type: none"> ● Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн тоо ● Нэвтрүүлсэн сургалтын технологи, инновацийн тоо ● Эмнэлзүйн суралцах орчны олон улсын стандарт, шалгууруудаас нэвтрүүлсэн тоо ● Бүтээлч сэтгэлгээ, суурь ур чадварыг төлөвшүүлэх, энтрепренёр боловсрол олгоход чиглэсэн хичээлийн тоо
3.2.	Дэлхийн шилдэг их сургуулиудтай	1. Дэлхийн шилдэг их сургуулиудтай төгсөлтийн	<ul style="list-style-type: none"> ● Төгсөлтийн өмнөх сургалтын хамтарсан хөтөлбөрийн тоо



	хамтарсан үндэсний онцлог бүхий сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.	өмнөх сургалтын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлнэ. 2. Дэлхийн шилдэг их сургуулиудтай төгсөлтийн сургалтын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ● Төгсөлтийн сургалтын хамтарсан хөтөлбөрийн тоо ● Англи хэл дээрх сургалтын хөтөлбөрийн тоо
3.3.	Үндэсний болон олон улсад магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийн тоог нэмэгдүүлнэ.	1. Төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн сургалтын хөтөлбөрийг үндэсний магадлан итгэмжлэл хийлгэнэ. 2. Төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн сургалтын хөтөлбөрт олон улсын магадлан итгэмжлэл хийлгэнэ.	<ul style="list-style-type: none"> ● Үндэсний магадлан итгэмжлэлтэй сургалтын хөтөлбөрийн тоо ● Олон улсын магадлан итгэмжлэлтэй сургалтын хөтөлбөрийн тоо
3.4.	Төгсөлтийн дараах сургалтын чанарыг сайжруулна.	1. Төгсөлтийн дараах сургалтыг Монгол Улсын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттай болгоно. 2. Төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийж, олон улсын жишигт нийцүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ● Төгсөлтийн дараах сургалтыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах эрх зүйн орчин бүрдсэн эсэх ● Шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн тоо
3.5.	Цахим сургалтын орчныг сайжруулж, сургалтын хөтөлбөрийн тоог нэмэгдүүлнэ.	2. Анагаах ухааны нээлттэй (цахим) боловсролын жишиг төв байгуулна. 3. Төгсөлтийн өмнөх, төгсөлтийн сургалтад цахим сургалтын хөтөлбөрийн тоог нэмэгдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ● Анагаах ухааны нээлттэй (цахим) боловсролын жишиг төв байгуулсан байна. ● Цахим сургалтын хөтөлбөрийн тоо
3.6.	Сурах бичгийг чанаржуулах, үндсэн сурах бичгүүдийг сургалтад ашиглах тогтолцоог бүрдүүлнэ.	1. Сургалтын чанар, суралцагчдын дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дэлхийн шилдэг их сургуулиудад хэрэглэгддэг сурах бичгийг албан ёсны эрхтэйгээр орчуулан суралцагчдад хүргэнэ. 2. Их сургуулийн багш нарын бүтээсэн үндсэн сурах бичгийн тоог нэмэгдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ● Орчуулсан сурах бичгийн тоо ● Их сургуулийн багш нарын туурвисан үндсэн сурах бичгийн тоо
3.7.	Оюуны өндөр чадамжтай, шилдэг суралцагчийг элсүүлнэ.	1. Дотоод, гадаадын шилдэг суралцагчийг элсүүлнэ. 2. Суралцагчдыг дэмжих тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ● Элсэгчдийн босго онооны өсөлт ● Гадаад оюутны эзлэх хувь



			<ul style="list-style-type: none"> ● Тэтгэлэгт хамрагдсан суралцагчдын эзлэх хувь
3.8.	Эрүүл чийрэг, эрдэм мэдлэгтэй Монгол хүнийг төлөвшүүлнэ.	<ol style="list-style-type: none"> 1. Оюутны хөгжлийн хөтөлбөр (2020-2025, 2026-2030) боловсруулж хэрэгжүүлнэ. 2. Суралцагчдын эрүүл мэнд, нийгэм хамгааллыг дэмжинэ. 	<ul style="list-style-type: none"> ● Оюутны хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь ● Суралцагчдын эрүүл мэндийн боловсрол, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, нийгэм хамгааллыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны тоо

Зорилт 4: Сургалтын ээлтэй орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн их сургуулийн хотхон байгуулах

№	Хэрэгжүүлэх стратеги	Арга зам	Хэмжих үзүүлэлт
4.1.	Их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.	<ol style="list-style-type: none"> 1. Орчин үеийн технологид суурилсан, суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ. 2. Олон улсын жишигт нийцсэн их сургуулийн номын санг байгуулна. 3. Спорт цогцолбор, соёлын төв зэрэг бүтээн байгуулалтыг гүйцэтгэнэ. 	<ul style="list-style-type: none"> ● Их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын гүйцэтгэлийн хувь
4.2.	Суралцагчдад ээлтэй орчныг бүрдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> 1. Оюутны хөгжлийн төв байгуулна. 2. Оюутны бүртгэл, мэдээллийг нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, цахимжуулна. 	<ul style="list-style-type: none"> ● Оюутны хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн оюутны тоо ● Мэдээллийн нэгдсэн тогтолцоонд шилжсэн эсэх
4.3.	Их сургуулийн шинэ өнгө төрхийг бий болгоно.	<ol style="list-style-type: none"> 1. Их сургуулийн брэндийг хөгжүүлж, шинэ өнгө төрхийг бий болгоно. 2. Их сургуульд маркетингийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> ● Их сургуулийн брэндийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны тоо ● Их сургуульд маркетингийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны тоо
4.4.	Хүн-байгальд ээлтэй орчныг хадгалж хамгаална.	<ol style="list-style-type: none"> 1. Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалж хамгаалахад чиглэсэн бодлогыг дэмжиж хэрэгжүүлнэ. 2. Их сургуулийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> ● Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалж хамгаалахад чиглэсэн бодлогын арга хэмжээний тоо ● Их сургуулийн нийт талбайд эзлэх ногоон байгууламжийн эзлэх хувь



			<ul style="list-style-type: none"> ● Байгальд ээлтэй, нөөцийн зохистой хэмнэлтийн үзүүлэлтүүд
--	--	--	--

Зорилт 5: Их сургуулийн эмнэлгийн тогтолцоог хөгжүүлж, олон улсын жишигт хүргэх

№	Хэрэгжүүлэх Арга зам	Хэмжих үзүүлэлт стратеги	
5.1.	Олон улсад магадлан итгэмжлүүлнэ.	<ol style="list-style-type: none"> 1. Олон улсын магадлан итгэмжлэл (JCI)-ийн стандартуудыг нэвтрүүлнэ. 2. Их сургуулийн эмнэлгүүдийг олон улсад эрэмбэлэх шалгуур үзүүлэлтүүдээр үнэлдэг болно. 3. Байгальд ээлтэй эко эмнэлэг болно. 	<ul style="list-style-type: none"> ● Олон улсын магадлан итгэмжлэлийн стандартаас нэвтрүүлсэн тоо ● Эмнэлгийн гүйцэтгэлийг олон улсын үнэлгээний аргачлалаар үнэлдэг болсон эсэх, түүний өсөлтийн хувь ● Байгальд ээлтэй, нөөцийг зохистой ашиглах менежментийг нэвтрүүлэн эко эмнэлгийн шалгуурыг хангасан байх
5.2.	Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний тоог бууруулна.	<ol style="list-style-type: none"> 1. Шинэ, дэвшилтэт технологийн чиглэлээр гадаадад мэргэжилтэн бэлтгэнэ. 	<ul style="list-style-type: none"> ● Гадаадад суралцсан мэргэжилтний тоо ● Шинээр нэвтрүүлсэн арга, технологийн тоо ● Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний тоог бууруулсан хэмжээ
5.3.	Эрүүл мэндийн шинэ, дэвшилтэт технологийг туршин нэвтрүүлж, зүгшрүүлнэ.	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн шинэ, дэвшилтэт технологийг туршин нэвтрүүлж, зүгшрүүлнэ. 2. Судалгаанд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлнэ. 3. Хиймэл оюун ухаанд тулгуурласан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр өндөр хөгжилтэй оронд мэргэжилтэн бэлтгэнэ. 	<ul style="list-style-type: none"> ● Их сургуулийн эмнэлэгт эрүүл мэндийн шинэ, дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн тоо ● Хийгдсэн судалгааны тоо, түүний үр дүнд үндэслэн хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо ● Их сургуулийн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд үнэлгээний тоо, сургалтад нэвтрүүлсэн ● Гадаадад суралцсан мэргэжилтний тоо ● Хиймэл оюун ухаанд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэвтрүүлсэн байдал



5.4.	Их сургуулийн эмнэлэг, сувиллын үйл ажиллагааг өргөжүүлнэ.	<ol style="list-style-type: none"> Их сургуулийн эмнэлгүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж нийслэлийн дүүрэг бүрд салбар эмнэлэгтэй болно. Монгол-Япон Эмнэлгийн өргөтгөлийг барьж байгуулан, төрөлжсөн мэргэжлийн салбар клиникүүдийг бүтээн байгуулна. Эрхэс, Баянчандмань сувиллыг дөрвөн улирлын үйл ажиллагаатай болгоно. Салбар сургуулийн эмнэлгийн үйл ажиллагааг нэгдсэн эмнэлгийн статустай болгож өргөжүүлнэ. Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны салбар сургуулийн эмнэлгийн харьяа сувилал байгуулна. 	<ul style="list-style-type: none"> Шинээр байгуулсан салбар эмнэлгийн тоо Эмнэлэгт шинээр нэмэгдсэн орны тоо Төрөлжсөн мэргэжлийн клиникийн тоо Дагнасан сувилахуй, түргэн тусламжийн үйлчилгээг үзүүлдэг болсон байна. Сувиллыг дөрвөн улирлын үйл ажиллагаатай болгох төслийн гүйцэтгэлийн хувь Дархан-Уул, Дорноговь аймаг дахь анагаах ухааны салбар сургуулиудын эмнэлгийг нэгдсэн эмнэлгийн статустай болгон өргөжүүлнэ. Дархан-Уул аймаг дахь Анагаах ухааны салбар сургуулийн эмнэлгийн сувиллын бүтээн байгуулалтын гүйцэтгэлийн хувь
5.5.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг их сургуулийн эмнэлэг, сувиллын тэргүүлэх чиглэл болгож, тусламж, үйлчилгээг хөгжүүлнэ. Эрүүл мэндийг дэмжих төвүүд байгуулна. 	<ul style="list-style-type: none"> Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг их сургуулийн эмнэлэг, сувиллын тэргүүлэх чиглэл болгож, тусламж, үйлчилгээг хөгжүүлнэ. Эрүүл мэндийг дэмжих төвүүд байгуулна.
5.6.	Их сургуулийн эмнэлгийн эм зүйн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулна.	<ol style="list-style-type: none"> Их сургуулийн эмнэлгүүд гадуур эмийн сантай болно. Эм түгээх тогтолцоо бүхий эмийн сантай болсон байна. 	<ul style="list-style-type: none"> Эмийн сан бүхий эмнэлгийн тоо Эм түгээх тогтолцоог нэвтрүүлсэн эмийн сангийн тоо

Зорилт 6: Их сургуулийн хөгжлийг дэмжих эрх зүйн шинэчлэл хийх

№	Хэрэгжүүлэх стратеги	Арга зам	Хэмжих үзүүлэлт
6.1.	Их сургуулийн дүрэм, журмын	1. Их сургуулийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг ханган	● Их сургуулийн шинээр болон шинэчлэн боловсруулж баталсан дүрэм, журмын тоо



	нэгдмэл байдлыг сайжруулна.	тогтвортой хөгжлийг дэмжихүйц эрхзүйн шинэчлэлийг хийнэ.	
6.2.	Боловсрол, эрүүл мэндийн салбар дахь их сургуулийн байр суурийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	1. Судалгааны их сургууль, их сургуулийн эмнэлгийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	<ul style="list-style-type: none"> ● Дээд боловсрол, судалгааны их сургуулийн холбогдох хуулиудад тусгасан заалтууд ● Эрүүл мэндийн тухай хуульд их сургуулийн эмнэлгийн статусыг тодорхой тусгасан байх

Зорилт 7: Ил тод, цомхон, хариуцлагатай, үр нөлөөтэй, сайн засаглалыг бэхжүүлэх			
№	Хэрэгжүүлэх стратеги	Арга зам	Хэмжих үзүүлэлт
7.1.	Их сургуулийн засаглалын тогтолцоог бэхжүүлж, нэр хүндийг нэмэгдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> 1. Төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд их сургуулийн нөлөөллийг нэмэгдүүлнэ. 2. Мэдлэг, ур чадвар, ёс зүй буюу чадахуйн зарчимд (мерит) тулгуурласан удирдлагын тогтолцоог хөгжүүлнэ. 3. Оновчтой бүтэц, зохион байгуулалт бүхий цахим технологид тулгуурласан сайн засаглалыг бэхжүүлнэ. 4. Хараат бус засаглал, шударга ёсны тогтолцоог бэхжүүлнэ. 5. Байгууллагын соёлын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлнэ. 6. Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бүрдүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> ● Төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо ● Ажилтнуудын сэтгэл ханамжийн өсөлтийн хувь ● Суралцагчдын сэтгэл ханамжийн өсөлтийн хувь ● Ажил олгогчдын сэтгэл ханамжийн өсөлтийн хувь ● Цахим засаглалыг бэхжүүлэх чиглэлээр нэвтрүүлсэн дэвшилтэт технологийн тоо ● Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний өсөлт
7.2.	Харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	<ol style="list-style-type: none"> 1. Дэлхийн шилдэг их сургуулиудтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ. Эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийн хүрээнд их, дээд сургуулиуд, олон улсын байгууллага, нийгэмлэгүүдтэй хамтран ажиллаж, судлаачдыг чадавхжуулна. 2. Төрийн өмчийн их сургуулиудтай сургалт, эрдэм шинжилгээ, 	<ul style="list-style-type: none"> ● Түншлэлийн гэрээний тоо, түүний хэрэгжилтэд хийсэн үнэлгээ ● Хамтын ажиллагаатай дотоод, гадаадын байгууллагын тоо ● Хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо ● Төрийн өмчийн их сургуулиудтай хамтран



		<p>мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.</p> <p>3. Олон улсын байгууллага, нийгэмлэг, холбоодын гишүүнчлэлийг нэмэгдүүлнэ.</p> <p>4. Багш, судлаачдын олон улсын хурал, семинар, форум, зөвлөгөөн, симпозиумд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.</p> <p>5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.</p>	<p>хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо</p> <ul style="list-style-type: none"> ● Олон улсын байгууллага, нийгэмлэг, холбооны гишүүнчлэлийн өсөлт ● Багш, судлаач, эмч нарын олон улсын байгууллага, нийгэмлэг, холбоодын гишүүнчлэлийн өсөлт ● Багш, судлаачдыг олон улсын хурал, семинар, форум, зөвлөгөөн, симпозиум зохион байгуулсан, оролцсон тоо
--	--	--	---

Зорилт 8: Эрдэм шинжилгээ, сургалт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, удирдлагын мэдээлэл технологийн нэгдсэн тогтолцоонд шилжих

№	Хэрэгжүүлэх стратеги	Арга зам	Хэмжих үзүүлэлт
8.1.	Мэдээлэл технологийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлнэ.	<p>1. Бүртгэл, мэдээллийн цахимжуулалтыг төгөлдөржүүлнэ.</p> <p>2. Цахим номын сан, эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн цахим сан байгуулна.</p> <p>3. Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтыг хангана.</p>	<ul style="list-style-type: none"> ● ERP системийг нэвтрүүлнэ. ● Мэдээллийн ил тод байдлын үзүүлэлт ● Шинээр байгуулагдсан институт, төвүүдийн тоо ● Цахим ном, бүтээлийн сангийн өсөлт ● Шинээр нэвтрүүлсэн мэдээллийн технологийн тоо ● Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны тоо
8.2.	Их сургуулийн эмнэлгийн мэдээллийн технологийг хөгжүүлнэ.	<p>1. Эмнэлгүүдэд мэдээллийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, өвчтөний түүх хөтлөлтийн программыг бүрэн нэвтрүүлсэн байна.</p> <p>2. Санхүү, удирдлага, эмнэлзүйн нийт 52 программын 75 хувийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.</p>	<ul style="list-style-type: none"> ● Их сургуулийн эмнэлгүүдэд нэвтрүүлсэн мэдээлэл технологийн тоо ● Эмнэлгийн мэдээллийн технологийг хөгжүүлэхэд зарцуулсан мөнгөн дүнгийн өсөлт ● Санхүү, удирдлага, эмнэлзүйн программаас нэвтрүүлсэн хувь



Зорилт 9: Санхүү, хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрт тогтолцоог бүрдүүлэх			
№	Хэрэгжүүлэх стратеги	Арга зам	Хэмжих үзүүлэлт
9.1.	Багш, судлаачдад зориулсан санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> Багш, судлаачдын эрдэм шинжилгээний ажлыг дэмжих зорилгоор их сургуулийн санхүүжилтийн 20 хувийг зарцуулна. Их сургуульд түшиглэсэн эндаумент сан байгуулна. 	<ul style="list-style-type: none"> Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь Багш, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлийг дэмжихэд их сургуулийн санхүүжилтээс зориулагдсан хувь
9.2.	Их сургуулийн санхүүгийн эх үүсвэрийг төрөлжүүлнэ.	<ol style="list-style-type: none"> Их сургуулийн орлогод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний орлогын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. Их сургуулийн гарааны компанийг дэмжинэ. Их сургуулийн санхүүгийн ил тод байдлыг хангана. 	<ul style="list-style-type: none"> Их сургуулийн орлогод сургалтын төлбөрийн эзлэх хувь Их сургуулийн орлогод эмнэлгийн орлогын эзлэх хувь Гарааны компанийн тоо
9.3.	Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог бүрдүүлнэ.	<ol style="list-style-type: none"> GMP шаардлага хангасан эмийн үйлдвэрийг байгуулна. Эрүүл мэндийн технологи арилжаалалтын тогтолцоог бүрдүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> GMP эмийн үйлдвэрийн төслийн хэрэгжилтийн хувь Эрүүл мэндийн технологи арилжаалалтаас их сургуульд оруулсан орлогын хэмжээ

**Арав. Хөгжлийн бодлогын хүрэх үр дүн,
гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт
(Key Performance Indicators)**

№	Хэмжих үзүүлэлт	Суурь түвшин 2020	2023	2025	2030
Хүрэх үр дүн 1: Шилдэг эрдэмтэн багш, эмч, суралцагчдыг төвлөрүүлж, хүний нөөцийн тасралтгүй хөгжлийг дэмжих тогтолцоо бүрдсэн байна.					
1	Дэлхийн шилдэг эрдэмтэн, эмчийг урьж ажиллуулсан тоо	-	10	25	50
2	Үндсэн багшид эзлэх гадаад багшийн хувь	1	2	3	5
3	Докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	40	50	60	70
Хүрэх үр дүн 2: Олон улсын жишигт нийцэхүйц судалгааны орчин, нөхцөлийг бүрдүүлсэн үндэсний тэргүүлэгч судалгааны их сургууль болсон байна.					



4	Олон улсад магадлан итгэмжлэгдсэн лаборатори, эмнэлгийн тоо	0	1	2	3
5	Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь	3.9	7	15	20
6	Нэг багшид ноогдох оюутны тоо	1:19	1:16	1:14	1:10
7	Бүтээл багшийн харьцаа Web of Science, Scopus, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо (нэг жилд)	1:14	1:11	1:8	1:5
8	АШУҮИС-аас эрхлэн гаргадаг Web of Science, Scopus, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн тоо	0	1	2	3
9	Үндэсний магадлан итгэмжлэлтэй төгсөлтийн сургалтын хөтөлбөрийн хувь	2	20	40	100
10	Оюуны өмчийн тоо	110	130	150	200
Хүрэх үр дүн 3: Дэлхийд өрсөлдөхүйц чадвартай эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэдэг болсон байна.					
11	Олон улсын болон дотоодын хамтарсан сургалтын хөтөлбөрийн тоо	2	3	5	10
12	Англи хэл дээрх төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн сургалтын хөтөлбөрийн тоо	1	2	4	6
13	Олон улсад магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийн тоо	1	3	4	6
14	Гадаад суралцагчдын эзлэх хувь	1	2	5	10
15	Тэтгэлгээр суралцагчдын эзлэх хувь	1	2	5	10
16	Цахим сургалтын хөтөлбөрийн тоо	8	10	20	30
17	Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь	65	68	70	75
Хүрэх үр дүн 4: Сургалтын ээлтэй орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн их сургуулийн хотхон байгуулсан байна.					
18	Их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын гүйцэтгэлийн хувь	70	90	90	100
19	Багш, суралцагчдад ээлтэй орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны тоо	1	5	10	20
Хүрэх үр дүн 5: Их сургуулийн эмнэлгийн тогтолцоог хөгжүүлж, олон улсын жишигт хүргэнэ.					
20	JCI олон улсын магадлан итгэмжлэлийн стандартуудыг нэвтрүүлсэн хувь	0	20	50	100
21	АШУҮИС-ийн брэнд инновацийн бүтээгдэхүүний тоо	7	15	25	30
22	Нийслэл хотод шинээр байгуулсан эмнэлгийн тоо	4	5	6	9
23	Дөрвөн улирлын үйл ажиллагаатай сувиллын тоо	0	1	1	2



24	Нэгдсэн эмнэлгийн статустай салбар сургуулийн эмнэлгийн тоо	0	0	1	2
25	Шинээр байгуулагдсан сувиллын тоо	2	2	3	4
26	Монгол улсад эмчлэх боломжгүй өвчний тоог бууруулах	26	25	20	15
27	Тэргүүлэх чиглэл болон зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн тоо	0	5	8	15
28	Шинээр нэвтрүүлсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрлийн тоо	1	3	5	10
29	Эм түгээх тогтолцоог нэвтрүүлсэн эмийн сан бүхий эмнэлгийн тоо	0	2	4	4
Хүрэх үр дүн 6: Их сургуулийн тогтвортой хөгжлийг хангах эрх зүйн шинэчлэл хийнэ.					
30	Их сургуулийн шинэчилсэн үндсэн баримт бичгийн тоо	1	3	3	3
31	Сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой үндсэн баримт бичгүүдийг шинэчилсэн тоо	-	20	20	20
32	Их сургуулийн эмнэлгүүдийн нэгдмэл байдлыг дэмжих чиглэлээр шинээр болон шинэчлэн боловсруулсан баримт бичгийн тоо	-	7	10	10
Хүрэх үр дүн 7: Ил тод, цомхон, хариуцлагатай, үр нөлөөтэй сайн засаглалыг нэвтрүүлсэн байна.					
33	Суралцагчдын сэтгэл ханамжийн өсөлтийн хувь	-	3	10	15
34	Ажилтнуудын сэтгэл ханамжийн өсөлтийн хувь	-	3	10	15
35	Төгсөгчдийн сэтгэл ханамжийн өсөлтийн хувь	-	3	10	15
36	Ажил олгогчдын сэтгэл ханамжийн өсөлтийн хувь	-	3	10	15
37	Хамтын ажиллагаатай гадаад байгууллагын тоо	100	120	150	200
Хүрэх үр дүн 8: Мэдээлэл технологийн нэгдсэн тогтолцоонд бүрэн шилжсэн байна.					
38	Их сургуулийн удирдлагын мэдээлэл (санхүү, хүний нөөц, ERP)-ийн тогтолцоог нэвтрүүлсэн хувь	20	100	100	100
39	Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний мэдээллийн тогтолцоог нэвтрүүлсэн хувь	50	100	100	100
40	Их сургуулийн эмнэлгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлсэн хувь	20	100	100	100
Хүрэх үр дүн 9: Санхүү, хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрт тогтолцоо бүрдсэн байна.					

СУРГАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ, ЖУРМЫН
ЭМХЭТГЭЛ



41	Их сургуулийн нийт төсөвт эмнэлгийн орлогын эзлэх хувь	5	10	20	30
42	Их сургуулийн нийт төсөвт суралцагчийн төлбөрийн эзлэх хувь	94	89	78	65
43	Гарааны компани, оюуны өмчийн бүтээгдэхүүн зэрэг бусад орлогын нийт төсөвт эзлэх хувь	-	1	2	5
44	Багш, ажилтнуудын үндсэн цалингийн өсөлтийн хувь	-	30	50	100
45	Их сургуулийн гарааны компанийн тоо	2	10	15	20
46	Эндаумент сангаар дамжуулан олгосон тэтгэлгийн тоо	-	10	30	80

Арван нэг. Бодлогыг хэрэгжүүлэх үе шат

Хөгжлийн бодлогыг 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат: 2021-2025 он

Хоёрдугаар үе шат: 2026-2030 он

Арван хоёр. Хөгжлийн бодлогын санхүүжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

Хөгжлийн бодлогын хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалтыг жил бүр АШУҮИС-ийн төсөвт тусгах бөгөөд ач холбогдол, үр дүн, өгөөжийг үндсэн шалгуур болгон санхүүжүүлнэ.

Хөгжлийн бодлогын хэрэгжилтэд АШУҮИС-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар жил бүрийн 11 дүгээр сарын сүүлийн 7 хоногт багтаан үнэлгээ хийж, санал, зөвлөмж, дүгнэлтийг АШУҮИС-ийн Захиргааны зөвлөлд тайлагнана. Хөгжлийн бодлогын стратеги төлөвлөгөөг үнэлгээнд үндэслэн жил бүр Захиргааны зөвлөлийн хурлаар батална. Шаардлагатай тохиолдолд явцын хяналтыг хийж болно.

Хөгжлийн бодлогын хэрэгжилтэд дунд хугацааны хөндлөнгийн үнэлгээг 3 жил тутамд хийнэ.